



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2026/036/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2026 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Захирал Д.Баатарсайхан Утас: 99099199 Цахим хаяг: Info@ghtaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.25 № 150

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцэст 56,774.8 мянган төгрөгийн өглөг бүртгэгдсэн бол 4,219.6 мянган төгрөгийн авлага бүртгэжээ. Энэ нь бүртгэсэн авлагаар өр төлбөрийг барагдуулах боломжгүй, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиг үүрэг алдагдах нөхцөл байдал үүссэн.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас тайланд онд 422,240.23 мянган төгрөгийг нэхэмжилсэн боловч 41,552.57 мянган төгрөгийг хасаж тооцсон бөгөөд хасагдлын шалтгаан үр дагаврыг аудитын цаг хугацааны явцад нарийвчлан тодорхойлох боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Бусад асуудлын хэсэг

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик

мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square stamp with Mongolian text. The text inside the stamp includes "Улаанбаатар" (Ulaanbaatar) at the top, "АДБОУС" (ADBOUS) in the center, and "Засаг захиргаа" (Zasag Zakhirgaa) at the bottom. A black ink signature is written across the stamp.

Г.ДАВАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	157,521,049.10	4,219,571.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	157,521,049.10	4,219,571.60
35	БАРАА МАТЕРИАЛ	78,595,272.16	85,368,382.36
351	Түүхий эд материал	20,745,103.50	19,937,566.70
35130	Эм боох материал	20,745,103.50	19,937,566.70
354	Хангамжийн материал	57,580,168.66	65,430,815.66
35410	Бичиг хэргийн материал	219,000.00	564,000.00
35420	Аж ахуйн материал	35,756,866.06	40,690,866.06
35440	Түлш, шатах тослох материал	687,720.00	2,212,767.00
35460	Хүнсний материал	7,228,300.00	4,860,900.00
35470	Бусад хангамжийн материал	13,688,282.60	17,102,282.60
35600	Мал амьтад	270,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,017,184,283.72	924,140,371.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,017,184,283.72	924,140,371.96
392	Биет хөрөнгө	1,004,992,783.72	912,347,871.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	495,889,336.19	495,889,336.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,692,863.01)	(48,516,201.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	182,800,000.00	182,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,928,571.92)	(100,542,857.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	649,479,966.77	670,629,808.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(279,937,758.41)	(351,866,040.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,217,439.40	58,348,439.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,858,515.80)	(35,047,821.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,470,000.00	72,970,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,446,249.50)	(32,316,791.01)
393	Биет бус хөрөнгө	12,191,500.00	11,792,500.00
39301	Программ хангамж	2,765,000.00	2,765,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,767,500.00)	(2,166,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,194,000.00	11,194,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,253,300,604.98	1,013,728,325.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	93,435,722.12	56,774,765.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	93,435,722.12	56,774,765.01
413	Өглөг	93,435,722.12	56,774,765.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	70,165,708.32	53,482,714.01
4136	Бусад өглөг	23,270,013.80	3,292,051.00
41361	Байгууллагад төлөх өглөг	23,270,013.80	3,292,051.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,159,864,882.86	956,953,560.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1,159,864,882.86	956,953,560.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	459,945,565.64	459,945,565.64
51101	Өмч: - төрийн	459,945,565.64	459,945,565.64
512	Хуримтлагдсан үр дүн	560,904,539.41	357,993,217.46

51210	Өмнөх үеийн үр дүн	560,904,539.41	548,376,625.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	(190,383,407.80)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,014,777.81	139,014,777.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,253,300,604.98	1,013,728,325.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,467,495,711.60	1,512,134,896.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,904,529.40	79,265,127.80
120	Нийтлэг татварын бус орлого	81,904,529.40	79,265,127.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,904,529.40	79,265,127.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	55,146,879.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	81,904,529.40	24,118,248.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,385,591,182.20	1,432,869,768.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,945,000.00	57,324,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,945,000.00	57,324,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,342,646,182.20	1,375,545,768.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,342,646,182.20	1,375,545,768.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,429,357,375.87	1,702,518,304.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,429,357,375.87	1,702,518,304.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,426,534,986.21	1,641,404,358.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,663,322.86	1,076,929,483.84
210101	Үндсэн цалин	527,534,130.80	529,553,899.19
210102	Нэмэгдэл	249,188,551.63	428,533,730.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,642,000.00	35,875,000.00
210104	Урамшуулал	98,298,640.43	82,966,854.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,184,067.81	138,829,580.84
210201	Тэтгэврийн даатгал	67,891,824.75	96,876,291.26
210202	Тэтгэмжийн даатгал	8,638,288.90	10,409,259.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,928,509.24	6,454,651.81
210204	Ажилгүйдлийн даатгал	3,610,004.62	4,951,053.79
210205	Эрүүл мэндийн даатгал	21,115,440.30	20,138,324.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,984,890.34	37,813,226.95
210301	Гэрэл, цахилгаан	6,723,604.74	10,816,474.95
210302	Түлш, халаалт	21,936,285.60	25,944,802.00
210303	Цэвэр, бохир ус	325,000.00	1,051,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,312,522.42	50,314,354.96
210401	Бичиг хэрэг	6,149,750.00	7,413,750.00
210402	Тээвэр, шатахуун	40,663,920.00	27,182,785.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,695,152.42	3,652,179.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,344,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,803,700.00	8,451,400.00
210408	Бараа материал акталсны зардал	-	270,000.00
2105	Нормативт зардал	145,031,828.90	126,986,726.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,706,354.90	105,392,426.10
210502	Хоол, хүнс	17,335,474.00	17,179,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,990,000.00	4,415,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,036,900.00	37,081,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,028,900.00	6,876,700.00
210604	Урсгал засвар	16,008,000.00	30,204,620.00
2107	Томилолт, зочны зардал	2,534,000.00	4,310,000.00
210702	Дотоод албан томилолт	2,534,000.00	4,310,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	35,357,237.50	32,683,952.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,357,237.50	32,683,952.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,430,216.38	136,455,713.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,895,100.00	12,630,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,535,116.38	123,824,753.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,822,389.66	61,113,946.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	54,268,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	53,148,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,822,389.66	6,845,946.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,822,389.66	6,845,946.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,138,335.73	(190,383,407.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,138,335.73	(190,383,407.80)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,247,795,110.10	1,641,318,125.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	55,146,879.50
120	Нийтлэг татварын бус орлого	-	55,146,879.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	55,146,879.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	55,146,879.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,247,795,110.10	1,586,171,246.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,945,000.00	57,324,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,945,000.00	57,324,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,204,850,110.10	1,528,847,246.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,204,850,110.10	1,528,847,246.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,223,793,850.27	1,631,572,125.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,223,793,850.27	1,631,572,125.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,220,971,460.61	1,571,376,179.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,502,815.35	1,119,443,959.14
210101	Үндсэн цалин	418,574,613.06	649,385,093.70
210102	Нэмэгдэл	249,188,551.63	334,487,958.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,642,000.00	32,700,600.00
210104	Урамшуулал	168,097,650.66	102,870,307.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,031,800.00	128,076,600.00
210201	Тэтгэврийн даатгал	59,181,900.00	83,630,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,962,300.00	11,103,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,551,800.00	6,579,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,410,800.00	4,569,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,925,000.00	22,193,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,672,610.34	38,388,053.95
210301	Гэрэл, цахилгаан	6,723,604.74	10,816,474.95
210302	Түлш, халаалт	22,624,005.60	26,519,629.00
210303	Цэвэр, бохир ус	325,000.00	1,051,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,316,110.42	51,864,974.96
210401	Бичиг хэрэг	6,149,750.00	7,553,750.00
210402	Тээвэр, шатахуун	36,861,520.00	30,389,605.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,695,140.42	3,652,179.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	-	1,087,640.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,609,700.00	9,181,800.00
2105	Нормативт зардал	119,921,887.00	147,369,195.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,730,137.00	124,336,445.80

210502	Хоол, хүнс	22,201,750.00	15,139,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,990,000.00	7,893,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,739,900.00	39,321,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,236,900.00	8,697,700.00
210604	Урсгал засвар	17,503,000.00	30,624,220.00
2107	Томилолт, зочны зардал	2,534,000.00	4,310,000.00
210702	Дотоод албан томилолт	2,534,000.00	4,310,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,357,237.50	30,198,366.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	35,357,237.50	30,198,366.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,895,100.00	12,403,110.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,895,100.00	12,403,110.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,822,389.66	60,195,946.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	53,350,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	52,230,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,822,389.66	6,845,946.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,822,389.66	6,845,946.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	24,001,259.83	9,746,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,480,000.00	9,746,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,480,000.00	9,746,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,480,000.00	9,746,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,480,000.00	9,746,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(28,480,000.00)	(9,746,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,478,740.17)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	657,181,627.88	1,256,141,971.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	657,181,627.88	1,256,141,971.33
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(134,415,424.20)	(134,415,424.20)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	522,766,203.68	1,121,726,547.13
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	522,766,203.68	1,121,726,547.13
D02	НББ-ын бодлогын өөрчлөлт	-	-	(12,527,914.15)	(12,527,914.15)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	510,238,289.53	1,109,198,632.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(190,383,407.80)	(190,383,407.80)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	459,945,565.64	139,014,777.81	319,854,881.73	918,815,225.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,777,291,300.00	1,634,472,179.85	142,819,120.15	91.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,777,291,300.00	1,634,472,179.85	142,819,120.15	91.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,685,004,900.00	1,581,122,179.85	103,882,720.15	93.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,151,069,400.00	1,119,443,959.14	31,625,440.86	97.25
210101	Үндсэн цалин	799,618,000.00	649,385,093.70	150,232,906.30	81.21
210102	Нэмэгдэл	185,356,900.00	334,487,958.13	(149,131,058.13)	180.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,880,000.00	32,700,600.00	12,179,400.00	72.86
210104	Урамшуулал	121,214,500.00	102,870,307.31	18,344,192.69	84.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,979,700.00	128,076,600.00	13,903,100.00	90.21
210201	Тэтгэврийн даатгал	92,317,200.00	83,630,400.00	8,686,800.00	90.59
210202	Тэтгэмжийн даатгал	12,256,900.00	11,103,400.00	1,153,500.00	90.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,349,300.00	6,579,100.00	770,200.00	89.52
210204	Ажилгүйдлийн даатгал	5,426,500.00	4,569,800.00	856,700.00	84.21
210205	Эрүүл мэндийн даатгал	24,629,800.00	22,193,900.00	2,435,900.00	90.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,024,000.00	38,388,053.95	6,635,946.05	85.26
210301	Гэрэл, цахилгаан	16,500,000.00	10,816,474.95	5,683,525.05	65.55
210302	Түлш, халаалт	27,324,000.00	26,519,629.00	804,371.00	97.06
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,051,950.00	148,050.00	87.66
2104	Хангамж, бараа материалын зардал	68,824,000.00	51,864,974.96	16,959,025.04	75.36
210401	Бичиг хэрэг	11,200,000.00	7,553,750.00	3,646,250.00	67.44
210402	Тээвэр, шатахуун	37,224,000.00	30,389,605.00	6,834,395.00	81.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	3,652,179.96	547,820.04	86.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	1,087,640.00	1,112,360.00	49.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,000,000.00	9,181,800.00	4,818,200.00	65.58
2105	Нормативт зардал	158,843,500.00	147,369,195.80	11,474,304.20	92.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	130,693,500.00	124,336,445.80	6,357,054.20	95.14
210502	Хоол, хүнс	19,400,000.00	15,139,750.00	4,260,250.00	78.04
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,750,000.00	7,893,000.00	857,000.00	90.21
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,300,000.00	49,067,920.00	9,232,080.00	84.16
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,000,000.00	18,443,700.00	7,556,300.00	70.94
210604	Урсгал засвар	32,300,000.00	30,624,220.00	1,675,780.00	94.81
2107	Томилолт, зочны зардал	6,210,000.00	4,310,000.00	1,900,000.00	69.40
210702	Дотоод албан томилолт	6,210,000.00	4,310,000.00	1,900,000.00	69.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,754,300.00	30,198,366.00	9,555,934.00	75.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	39,754,300.00	30,198,366.00	9,555,934.00	75.96

	үйлчилгээний төлбөр хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	12,403,110.00	2,596,890.00	82.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	12,403,110.00	2,596,890.00	82.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,286,400.00	53,350,000.00	38,936,400.00	57.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,286,400.00	53,350,000.00	38,936,400.00	57.81
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,756,400.00	-	34,756,400.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	53,230,000.00	52,230,000.00	1,000,000.00	98.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	1,120,000.00	3,180,000.00	26.05
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,777,291,300.00	1,634,472,179.85	142,819,120.15	91.96
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,324,000.00	50,478,053.95	6,845,946.05	88.06
132001	Орон нутгийн төсвөөс	57,324,000.00	50,478,053.95	6,845,946.05	88.06
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,630,282,000.00	1,528,847,246.40	101,434,753.60	93.78
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,630,282,000.00	1,528,847,246.40	101,434,753.60	93.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,685,300.00	55,146,879.50	34,538,420.50	61.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,685,300.00	55,146,879.50	34,538,420.50	61.49
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00

Гурав . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар 7 алдаа, зөрчил илэрснээс 2 алдааг залруулж, 3 зөрчилд зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн.

- НДШ болон ХХОАТ-ын өглөгийн дансны харьцаа, журналын бичилтийг дутуу хийж, зардлын данс руу хаасан нь ажил гүйлгээний иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.
- Өр төлбөр, авлагын тодруулга тайланд 1 харилцагчийг 2 өөрөөр кодолж бүртгэснээс бүртгэлээр тавих хяналт сулрах, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, бодитой оршин байх батламж мэдэгдэл хангаагүйг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 4,010.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1 албан шаардлага, шилэн дансны дутуу мэдээлсэн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгийн ашиглалт, зардлын данс, өглөг, авлагын данстай холбоотой 3 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл “тооллогын комисс, түүний эрх, үүрэг”, 73 дугаар зүйл “эд хөрөнгийн тооллого явуулах журам”-ыг үндэслэн жилийн эцсийн бараа материалын дансанд тооллого хийгээгүй нь оршин байх, тасалбар болголт зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үлдэх өртөггүй 70 нэр төрлийн 94ш хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг дахин ашиглагдах боломжтой, боломжгүй эсэхийг өмч хамгаалах комиссоор оруулж, ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох асуудлыг Орон нутгийн өмчит газарт уламжлан шийдвэрлүүлэх, хамгаалалтыг сайжруулах, ашиглах боломжгүй хөрөнгийг эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж бүртгэлээс хасах;

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөхдөө E barimt цахим системээс 4,010.5 мянган төгрөгийн нэхэмжлэхээр ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна. Нэхэмжлэхийг төлбөрийг төлсөн боловч харилцагч байгууллага нь нэхэмжлэхээ хааж төлбөрийн баримт үүсгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг төлсний дараа тухайн байгууллагаасаа нэхэмжлэхийг хаалгаж төлбөрийн баримтыг авах

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст 56,774.8 мянган төгрөгийн өглөг, 4,219.6 мянган төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд авлага, өглөгийн зохистой харьцаа алдагдсан байна. Үүссэн өр төлбөрийг барагдуулахад гүйцэтгэлийн санхүүжилт хүрэлцэхгүй, өрийг хэрхэн барагдуулах төлөвлөгөө тодорхойгүй байгаа нь санхүүгийн хүндрэл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж, цаашлаад иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, хүртээмжтэй хүргэх чиг үүрэгт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэж байна.

Өгсөн зөвлөмж: Өр, авлагын харьцааг оновчтой түвшинд хүргэх зорилгоор авлага барагдуулах, өглөг бууруулах төлөвлөгөөг үе шаттай боловсруулж хэрэгжүүлэх, зардлын бүтэц, гүйцэтгэлийн санхүүжилтийн уялдааг нарийвчлан тооцож санхүүгийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллагад санхүүжилтийн эх үүсвэрийн зохицуулалтын санал хүргүүлж, өр төлбөрийн удирдлагыг тогтмол хянах механизмыг бүрдүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв	2	-			2		2		-	-	-	-
Дүн	2	-	-	-	2	-	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв	4	4,010.5			1		3	4,010.5	-	-	-	-
Дүн	4	4,010.5	-	-	1	-	3	4,010.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв	1				1			
Дүн	1	0	0	0	1			

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-